

СҮМ ХИЙДИЙН ТАРИАЛАН ЭРХЛЭЛТИЙН АСУУДАЛД

Б.ПУНСАЛДУЛАМ

Товч агуулга: Монголын сүм хийдүүдэд XVIII зууны II хагасаас тариалан эрхлэж ашиг, орлого олох боломжууд бүрэлдсэн байна. Сүм хийдүүд байгаль, газар зүйн таатай нөхцөлд оршдог. Шавь нарын тоо улам бүр өсөн нэмэгддэг. Сүм хийдийн аж ахуй, зохион байгуулалтын үйл ажиллагааны хэлбэрт шилжсэн зэрэг давуу талууд тариалан эрхлэх боломжийг нэмэгдүүлжээ.

Түлхүүр үг: Тариа, арвай, сүм хийд, жас, гадаад сан, сүйлэн авах, суумал.

XVIII зууны II хагасаас хутагтын зоог, сүм хийдийн хурал номын хэрэгцээнд зарцуулах тариа тарих ажил үүсэж, сүм хийдийн сан хөмрөг томорчээ. Монголд бурхны шашны сүм хийдийн тоо улам бүр нэмэгдэж баялаг нь арвижиж байв. 1918 онд И.Майскийн тоолсноор 2749 сүм хийд Ар Монголд байжээ. Үүнээс ардын хувьсгалын өмнө тус орны 60 орчим хийдийн шавь албат¹ нар тариа тарьж байснаас Живзундамба хутагтын сан 40 шахам газарт² тариа тарьж байжээ.

Судлаачид Монголын тариалан эрхлэлтийг газар зүйн байрлалаар 1. Орхон Сэлэнгийн буюу умард голомт, 2. Алтайн их нурууны голын сав буюу өрнөд голомт, 3. Хангай нурууны тариалангийн голомт. 4. Их нууруудын хотгорын зарим баян бүрд орчмын голомт, 5. Улз, Онон, Халх, Нөмрөг гол, Хөлөн буйр хавийн Дорнод голомт гэж ангилж иржээ. Тариалангийн умард нутагт халх, цахар, буриад, орос, хятад иргэд тариа тарьж байсныг жуулчид тэмдэглэн үлдээжээ. Өрнөд голомтод халх, дөрвөд, захчин, мянгад өөлд, торгууд болон бусад ардууд тариалж байв. Хангай нурууны өвөр, говийн Алтайн баян бүрдүүдэд халхууд, Халх Нөмрөг голын саваар халхууд, Онон, Улз орчмоор буриадууд тариалж байв. Монголчууд ойр зуурын хүнсэнд зориулж арвай, үст арвай, улаан буудай, бог будаа, хошуу будаа, овъёс тариалсаар иржээ. Монголын тариалагч ардууд зөөлөн болон жижиг / карликовая/, хатуу буудайн 3 янз дүрс тариалж ирснээс зөөлөн буудай давамгайлж байжээ. Хатуу буудайг зөвхөн Ховдод зөөлөн буудайн хамт тариалж байжээ гэж судлаачид үздэг бөгөөд үүнд үндэслэн хатуу буудайг тариалдаг Дэлхийн

¹ Пүрэвжав, С. *Монгол дахь шарын шашны хураангуй түүх*. Улаанбаатар: БНМАУ-ын СнЗ-ийн Улсын Дээд, тусгай, дунд, техник, мэргэжлийн боловсролын хорооны хэвлэл, 1978, 155.

² Насанбалжир, Ц. Живзундамба хутагтын сан. // *Түүхийн судлал*. Том.VII. Fasc.13-24, 149.

бөмбөрцгийн хамгийн зүүн хэсгийн бүс нутаг хэмээн тодорхойлжээ.

XVIII зууны Их хагасаас Монголын сүм хийдүүд тариалан эрхлэж ашиг, орлого олох боломжууд бүрэлдсэн байна. Үүнд:

1. Сүм хийдүүд тариалан эрхлэх боломж бүхий газар нутгийг эзэмших эрхээр хангагдсан байв. Живжундамба хутагтад Халхын дотор аль шилдэг сайн газар билчээр, тариалан, хадлангийн ашиг шим бүхий газрыг эзэмшин өмчлөх тухай дархан эрхийг удаа дараа олгож байжээ. 1772 онд Ширээ нуурын зэрэг газар Халхын 4 аймгийн хангууд, зарим хошууны ноёд түшмэд Улиастайн жанжин ван, Живжундамба хутагтын да лам нар чуулж Живжундамба хутагтын шавь ардын нутгийн асуудлаар хэлэлцэн тогтоосон “...Өндөр дүрээс янагш ...Дээрхийн шавь нарыг 4 аймгийн дотор аль дуртайгаар нутаглаж...4 аймгийн засгуудын нутагт хуучин хэвээр нутагласугай хэмээн тогтоов”³, Тэнгэрийг тэтгэсний 47 /1782/ онд олон аймаг, хошуу, шавь, өртөө харуул, албан сүрэг малын нутаг бэлчээрийг тус тус зааж, зураг цэс бүхий болгон тогтоосноос хойш Живжундамба хутагтын шавь нарыг олон аймаг хошууны нутагт нутаглууж, тусгай газар бэлчээр заан олгож газрын зураг цэс тогтоон нутаглуулсаар иржээ. Түүний шавийн харъяат ардууд Халхын 40 гаруй хошууны дотор тусгай зураг цэс бүхий нутаг ихээхэн газар бэлчээр эзлэн нутаглаж, зарим хошуудын ардуудыг бэлчээр, тариалан хадлангийн газраас шахан зайлуулж байжээ. Живжундамба хутагтын шавь нарын тоо XX зууны эхээр 55475-д хүрч байсныг судлаачид гаргажээ⁴. 1775 оноос эхлэн Живжундамба хутагтын сан ба түүний харъяат хүрээ хийдийн жасад тариа тарих газруудыг Түшээт хан аймгийн зарим хошуудаас олгож эхэлжээ. Сэлэнгийн газар Еэвэн, Бургалтай, Бороо, Бор нуур зэрэг нилээд газарт шавийн гурван отгийг албадан гаргаж тариа тариулж, цагаан гурил, арвай, буудай зэрэг үр тариаг хутагтын санд хураан авч байжээ. Сангийн тарианы ажилд 200 гаруй өрх, 2000 илүү хүн ам хамрагдаж байв.

Монголын тамгатай 13 хутагтын эзэмшил газар нутаг нь Сэцэн хан аймагт-2, Засагт хан аймагт-3, Сайн ноён хан аймагт-8 оногдож байжээ. Эдгээр тамгатай хутагтуудын шавийн харъяат нутаг дэвсгэрийн 71,4 хувь нь зөвхөн Сайн ноён ханы нутагт оногдож байв. Тамгатай 9 хутагтын газар нутаг Хангай нуруу, түүний салбар уулсыг дамнасан буюу арлаж, өвөрлөн Идэр, Чулуут, Хануй, Хүнүй, Хойд, Урд Тамир, Завхан, Байдраг, Өлзийт, Түйн голын сав дагуу эсвэл эдгээр голуудыг хөндлөн огтолсон байрлалтай ажээ. Монгол нутгийн тамгатай хутагт

³ Насанбалжир, Ц. Живжундамба хутагтын сан. *Түүхийн судлал*. Том. VII. Fasc.13-24, 147.

⁴ Цэдэв, Д. *Их шавь*. Улаанбаатар: Шинжлэх ухааны академийн хэвлэл: 1965, 25.

нарын газар нутгийн 40,8 хувийг эзэлсэн Сайн ноён хан аймгийн Эрдэнэ Бандид /ламын гэгээн/ хутагтын шавийн харъяат нарын нутаг нь хөрс, ургамлын хамгийн олон төрөл бүхий байгалийн сайхан бэлчээр, тариалангийн талбайтай байжээ. Хамгийн том нутагтай нь: Сайн ноён хан аймгийн Эрдэнэ бандида хутагт 27,533 ам км нутагтай. Дараа нь Зая бандид хутагт 7192 ам км нутагтай ажээ⁵ Тамгатай бүх хутагтын харъяат нарын нутгийн 26,9 хувь байгалийн ойт хээрийн бүс, 15% нь хээрийн, 9,8 хувь говийн, 3,3 хувь ойт хээр, хээрийн, 42 хувь хээр, говийн бүсэд тус тус оршиж байв. Өөрөөр хэлбэл Монголын тариалан эрхлэх боломжтой газар нутгийг эзэмшиж байсан нь сүм хийдийн аж ахуй тариалан эрхлэх байгал, цаг уурын нөхцөл боломжийг бүрдүүлсэн байна.

2. 1658 оны эхээр Манжийн засгийн газраас Монгол лам нарын тоог хязгаарлах бодлого барьж, лам нарыг бүртгэлд ороогүй лам болохыг хориглож байв. Хошуу бүрт байх лам нарын тоог 40 байхаар тогтоож хуулиар хориг тавьсан боловч тэдний тоо хэдэн зуу болон нэмэгджээ. Манжийн бодлогоор гэрийн хүмүүс, боол, хөвгүүд, хамжлага, сул эм, насанд хүрээгүй хүмүүс, өтөл насны хүн, насанд хүрээгүй тайж хүн шавь болж болох боловч (1775 онд бүх тайж нарыг лам болохыг хоригложээ) нэмэгдсээр л байв. Үүнтэй уялдан “сул шавь” тайжийн хамжлагаас чөлөөлөгдсөн хүнийг, “цагаан шавь” гэрийн боол шавийг хэлж нэрлэх болжээ. 1817 онд Манжийн хаан сүм хийдэд өргөн барьсан албатыг бүртгэн аваад тухайн хошуунд буцаан өгөх зарлиг буулгажээ⁶. Гэвч амьдралд хэрэгжсэнгүй шавийн тоо өсөн нэмэгдсээр байв.

Монголын нийгэмд лам, шавь болох сонирхол их байхын зэрэгцээ, шавьд элсэх хүнийг хөрөнгө чинээ ялгалгүй дуртай хүлээн авч байв. Ардууд үр хүүхдээ боловсрол эзэмшүүлэх гол арга нь лам болгох байжээ. Нөгөө талаар язгууртнууд лам санваартан болох боломжгүй байсан тул тэдэнд сүм хийдэд зэрэг дэв олж дэвших боломж илүүтэй байжээ. Үүнээс гадна шавьд орох, лам болоход нийгмийн олон талын нөхцөл бодитой нөлөө үзүүлжээ. Тухайлбал, лам нар цэргийн алба, ан хомрогын алба, өртөө улааны албанаас чөлөөлөгддөг, өгч буй албан татвар нь арай хөнгөн, лам нарыг доромжилсон хүнийг чангалан шийтгэх хуультай, лам нарыг буруу үйл хийвэл эхлээд шар шувталсны дараа шийтгэдэг, нийгэмд лам нарыг бурхны шавь хэмээн хүндлэх сүсэг бишрэлийн сэтгэлгээ давамгайлсан, өргөл барьц, мэргэ төлөг үзэх, эм барих зэргээр мөнгө орлого олж амьдрах боломж

⁵ Пүрэв, О. *Монгол улсын түүхэн газарзүй*. Улаанбаатар: Эдмон: 2004, 34.

⁶ Лан Мэй Хуа. *Монголын тусгаар тогтнолын хөдөлгөөн: Нэгдсэн Монгол улс байгуулах эрмэлзлэл*. Улаанбаатар: Соёмбо принтинг, 2011, 41.

энгийн ардуудтай харьцуулахад өргөн ажээ. Лам харын хооронд завсардах боломж нь сум ард, шавийн ард хоёрын ашигтай талыг хослуулснаар хувь иргэний амьдралд тустай талыг өгч байв. Ингэж завсардах нь лам өрхөд цэргийн алба татвар, албан татвар оногдуулахад үлэмж чирэгдэл маргаантай байжээ. Энэ асуудлыг шийдвэрлэхийг оролдсон ч үр дүнд хүрээгүй юм.

3. Шавь нарын тоо улам бүр өсөн нэмэгдэж байхад нутаг газар тэлэхгүй, эзэмшил нутаггүй байх бодит байдал нь сүм хийд, хутагт хувилгаадын аж ахуй илүү зохион байгуулалттай, аж ахуйн шинжийг олох нийгэм, эдийн засгийн шаардлагыг нөхцөлдүүлсэн байна. Өөрөөр хэлбэл Монголын сүм хийдүүд XVIII зууны II хагасаас тухайн үеийн нийгмийн үйлдвэрлэл, хуваарилалтын процесст оролцож тодорхой үүргийг гүйцэтгэх болжээ.

XVIII зууны үеэс Монгол орон дэлхийн зах зээлийн системд татагдан орсонтой уялдан өөрийн сүм хийдийн дотоод хэрэгцээгээ хангаж байсан сан, жас жавууд орон нутгийн зах зээл үүсгэхэд тодорхой хувь нэмрийг оруулахын хамт нийгмийн шинэ харилцаанд идэвхтэй оролцох болжээ. Монгол оронд худалдаа наймаа голдуу сүм хийд, хот суурин газрыг /Богдын Хүрээ, Хиагт, Улиастай, Ховд, Вангийн хүрээ, Заяын хүрээ, Улаангомын хүрээ, Ламын гэгээний хүрээ, Эрдэнэ зуу, Амарбаясгалант, Баруун хүрээ, Дөрвөдийн далай ханы хүрээ гэх мэт / бараадан хийх болж түүнд сүм хийдүүд идэвхтэй оролцох болжээ.

Дээрх газруудад худалдаа арилжаа хийгчдийн бүрэлдхүүнийг Хиагтын зах зээлээр төлөөлүүлэн авахад /Хиагт бол сүм хийдийг түшиглэн байгуулдагдаагүй хилийн боомт, худалдааны газар юм./хэдийгээр тус хотод оршин суух ламын тоо төдий л их биш, 16 лам байжээ⁷, Харин Хиагтын худалдааны зээл дээр сүм хийдүүд давамгалан оролцож иржээ. 1913 оны 10 сард Сайн ноён хан аймгийн хошуу, түүний дотор Далай Чойнхор вангийн хошууны Майдар, Мамба, Чойл, Дашасамдилиин, Чойнхор хурал зэрэг 7 сан жас Хиагт, Нийслэл хүрээ хоёрт 59455 жин шар тос, мөн хошууны лам Жунай, Ширчинжанцан, Цэвэг, Аюуш, Дашням нар 15875 жин шар тос, мөн оны 12 сард дээр дурдсан жасууд зөвхөн Хиагтад дахин 37110 жин шар тос заржээ⁸. Живзундамба хутагтын сүм хийдүүд Монголын тариалангийн Умард голомт буюу Орхон, Сэлэнгэ, Хараа, Ерөө голын сав нутагт ойр байдгийн хувьд Хиагтын зээл дээрх газар тариалангийн бүтээгдхүүнийн арилжаанд оролцож ирсэн нь дамжиггүй юм. 1917 оны гаалийн мэдээгээр Хиагтын зээл дээр гурил 25136 жин, муу гурил 420 жин, шар будаа 24000 жин тус

⁷ Идшиннорв, С. Хиагтын Монгол худалдааны тухай. // *Түүхийн судлал*. Том. XVIII. 1984, 50.

⁸ Идшиннорв, С. мөн тэнд

тус зарагдсаны 91 хувь нь ургац хурааснаас хойг намар өвлийн улиралд ноогдож байна. Мөн 1917 оны Хиагтын зээл дээрх түлээний модны арилжааны 6,06 хувь нь шавийнханд, өвсний 10,02 хувь нь ноогдож байна.⁹

4. Манжийн үед ч, 1911 онд Монгол улс тусгаар тогтнолоо олсны дараа ч лам, шавь нарыг нийгмийн олон төрлийн алба гувчуураас чөлөөлсөн нь шавь болох явдлыг улам нэмэгдүүлэхийн хамт сүм хийдүүд тариа тарьж ашиг олох боломжийг хууль эрх зүйн хувьд олгосон байна. Их шавийг олон аймгийн өрх цэргийн зэрэг албанд хавсаргахгүй болгохоор МУ-ын Зарлигаар тогтоосон хууль зүйлийн бичгийн арван нэгдүгээр дэвтэрт “Нэгэн зүйл. Живзундамба ламын шавь нар болбоос язгуураас тусгайлан эрхэлсэн сүм, хурлын хэрэглэл ба ламын зоог, тахилыг дагнан гаргаж явахын тулд харъяат Их шавийг олон аймгийн өрх цэргийн өртөө улааны зэрэг албанд үүрд хавсаргахгүй болгогтун” гэжээ¹⁰. Мөн хууль зүйлийн бичгийн арван хоёрдугаар дэвтэрт Сангийн амууны тухай хуульчилжээ. Түүнд, хэрэв тариаг бүрнээ тушаан өгч чадахгүй бол, нэгэн жилийн хугацаа сунгаж, хойд жилд хуучнаар шинийг хамтаар эрхгүй гүйцээн өг. Хэрэв дутуулсаар гурван жилд гүйцэтгэн тушаахгүй болбоос уг хурааваас зохих амууг үнэ бодож харъяат хошуунаас тулган төлүүл. Дахин тариулах, үл тариулах явдлыг тухайд Сангийн яамнаас магадыг барьж тогтоон шийтгэгтүн” гэсэн заалт хэдийгээр Живзундамба хутагтын болон бусад хутаг хувилгаад, сүм хийдийн тариаланд үйлчлэхгүй боловч, тэд дотооддоо шавь ардаас тарианы татвар авахад энэ хууль үйлчилж байв.

Монгол газар тариа тарьж буй сүм хийдийн дотор тэргүүлэх байр суурийг тариалангийн Умард голомтод байрлах Живзундамба хутагтын их шавь, түүний харъяа сүм хийдүүд эзэлж, удаах байрыг газар нутгийн хэмжээгээрээ хамгийн ихтэйд тооцогдох Монголын тамга хутагтын нэг Эрдэнэ бандид хутагтын харъяа сүм дацан, жасууд, удаах байрыг тариалангийн Өрнөд голомтод байрлах Ховд хязгаарын Дүрвэд баруун гарын Зоригт ханы хошуунд 7 том жас (Улаангомьн хүрээ), зүүн гарын Далай ханы хошууны Төгсбуйантын хийд, Баяд хошууны Цалгарын хүрээний том жасуудын тариалан орно.

Монголын сүм хийдийн тарианы ажлыг тухайн хийдийн Гадаад сан хариуцна. Гадаад сан аж ахуйн ажлыг хариуцах бөгөөд түүнийг “Их сан” гэж нэрлэдэг. Гадаад сан нь сүм, хийд хутагтын бүх зоог тахил, түүний дуган сүм, орд өргөө, орон сууц барих, сэлбэх, хүрээ хийдийн хурал номын зардал нийлүүлэх, сүрэг

⁹ Идшиннорв, С. Хиагтын Монгол худалдааны тойм. *Түүхийн судлал*. Том. XVIII. 1984, 53.

¹⁰ *Монгол төр, эрх зүйн түүх* (Дээж бичиг). Эмх./ред. Б.Баярсайхан. Улаанбаатар: 2010, 92.

мал адуулах, үржүүлэх, арилжаа худалдаа хийх, хөсөг тээвэр хөдөлгөх, тариалан тарих, хадлан хадах, мөнгө цай хүү үржүүлэн зээлдүүлэх ба зээлдэн авах, зээлийг төлөх, алба татвар хураах, сангийн орлого зарлагын данс тайлан тооцоо хийх, хөрөнгө хогшлыг бүртгэх, сан шавийн дотор зарцуулах тийз (мөнгөний цаасан тэмдэгт) гаргах, тариалан хадлангийн газар түрээслэх, өргөл барьц хүлээн авах, бадар хандив эрэх, санд ажиллуулах хүмүүсийг албачлан гаргах зэрэг аж ахуй, санхүүгийн бүх ажлыг хийнэ.

Сүм хийдүүд шавь ардуудын хүч, хөдөлмөрийг ашиглан хөх арвай, буудай, хар будаа тариалж байв. Сүм хийд, жасууд тариагаа ардаар албадан тариулдаг учир, түүнийг нутгийн хүмүүс “албаны тариа” гэж нэрлэнэ. Сүм хийдүүд санд жил тутам нийлүүлэх тарианы тоо хэмжээг 5 дү (100 кг) тариагаар тогтоож заавал гүйцэтгэх үүргийг хүлээлгэн нормт тариаг тухай нь жил дутуу тушаавал дараа жил заавал нөхөж өгөх үүргийг хүлээн, өгч чадахгүйд хүрвэл тохирох үнээр төлүүлэн санд заавал авдаг байжээ. Нэг их Дү тариа 40 шанаг, буюу 20 кг, бага дү нь 20 шанаг 10 орчим кг болно.

Архивын баримтаас харахад Бүрэн засагчийн 5-р онд (1866) сангийн тарианд 19 өрхөөс 120 дү 45 жин хураахдаа 10-аас 5 дүгийн хороонд тушаасан байна. Үүнд, Жамбын барьсан 21 дү 10 сан тариаг 2-р оны дутуу 9 дү, 4-р оны 10 дү, 5-р оны 1 дү, 10 сан тарианд хаагаад одоо дутуу 8 дү 10 сан тариа болно. Мөн Дугаржавын Дамирын барьсан 7 дү, 5 сан тариаг 2-р оны дутуу 3 дү, 3-р оны 5 сан, 5-р оны 4 дү тарианд хаагаад эдүүгээ 1 дү дутуу, Дамбын Шагдарын барьсан 5 дү тариаг энэ намрын 5 дү тарианд хаав гэсэн бичиг үйлдсэнээс үзвэл 5 дү тариаг жилдээ өгч байжээ. Өр болон үлдсэн тариаг хааж чадахгүй болсон тохиолдолд мал болон эд зүйлээр нөхөн хаадаг байжээ. Тухайлбал, Сэргэлэнгийн Доржжавын барьсан 1 их ирэг, 2 ямааг 9-р оны 2 дү 15 сан тарианд хаав. Балдарын барьсан 4 их ирэгийг 9 оны намрын 5 дү-д хаав гэх мэтээр данс хөтөлсөн байна. Мөн нормт тарианаас гадна хутагтын сангаас зээлсэн эд барааны үнийг тариагаар төлдөг байжээ. Д.Шагдарын барьсан 8 дү тариаг 6 онд зээлсэн 1 хатуу цай мөн оны 6 дутуу 1 дүд хааж энэ намрын 4 дүд хааж 1 дү болно. гэснээс үзвэл цайны үнэ 3 дү тариа болжээ. Мөн тариа 1 дү буюу 40 шанагт хүрэхгүй бол, шанагаар тооцож авдаг байжээ. Ц.Санги 4 дү 13 шанаг тариаг энэ намрынхад хаагаад дутуу 17 шанаг тариа гэх мэт¹¹ тэмдэглэсэн байна.

Монгол улсын хууль зүйлийн бичигт Живзундамба ламын сангийн зэрэг газрын амуу тариаг хуучин ёсоор явуулах нь Нэгэн зүйл: Олон чуулганы хошууны

¹¹ УТА. М-76-1-16

нутаг Живзундамба ламын сан Их шавийн хааръяат олон хүрээ, сүм, дацан, аймаг орны тахил тавиглалын хэрэглэлд туслан өгч тариулсан амуу тариаг одоо явуулах хуулийг нийтээр тархаан явуулснаас урьдахыг нь нутгийн харъяат хошуу, Нийслэл Хүрээний Эрдэнэ шанзудба нарын газраа нэгэн хамтаар магадлан байцаалгаж аль чуулган, хошууны нутгийн ямар хэдэн газарт, аль сан, хүрээ, сүм, дацан, аймаг орны ямар зүйлийн тариа тариулсан явдлыг нарийвчлан хэмжээлж байдал төлөвийг нь зураг зурж тодорхойлон Сангийн яамнад өргөн мэдүүлж хууль ёсоор гурван жилд нэг удаа хугацааны тэмдэгт бичиг хүлээн авхуул. Бас ч олон хошуу, шавь, харуулын өөр өөрийн сүм, хурлын хөрөнгө болгосон тариан буй аваас нэгэн адил шийтгүүл. Цөм албан сангийн түрээс хураахыг бүрнээ хэлтрүүлэгтүн”¹² хэмээн заажээ.

Хуулийн энэ заалт сүм хийдийг газраа бусадад түрээслүүлж давхар ашиг олох боломжийг эрх зүйн хувьд баталгаажуулсан байна. Сүм хийдүүд газраа шавь, лам, монгол хүмүүс, хятадуудад түрээслэж байв. Нөгөөтэйгүүр сүм хийдээс газар түрээслэж авах нь хүмүүст ялангуяа хятад иргэдэд илүү хөнгөн нөхцөлтэй тусч байсан юм.

XX зууны эхэнд Живжундамба хутагтын шавийн ардууд Еэвэн, Бургалтайн тарианы газраас нэгэн жилд гурил 67 мянган жин, арвай 3 шахам мянган жинг хутагтын санд албан журмаар нийлүүлж байв. Богдын сангийн тариаг шавийн гурван отгийн ардууд гүйцэтгэж, тэднийг тарианы даамал хариуцаж байв. 1902 онд Бадаргуулт төрийн үеэс хятадуудад Монголд газар тариалан эрхлэх боломжийг албан ёсоор зөвшөөрч, улмаар хятад, монголчуудыг хамтран ажиллахыг уриалах Шинэ засгийн бодлого сүм хийдүүд тарианы газраа хятадуудад түрээслэн ашиг нөхцөл, боломжийг нэмэгдүүлсэн байна. Живжундамба хутагтын сан нилээд газрыг хятадын тариачдад түрээслэн өгч хөлсөнд нэгэн жилд 136 мянга гаруй жингээс доошгүй /81600 кг/гурил хураан авч байжээ. Үүний хамт лам нар, хятад тариачдад түрээслэж байжээ. Шавийн лам Лувсанжамъян бор гурил 2500 жин, цагаан гурил 5500 жин өгөхөөр тарианы газар түрээслэн авч уул гурилыг тариачин хятад Мэндбаяр, Сайнбаяр нарын хамт Богдын санд нийлүүлж байжээ¹³. Эдгээр хүмүүс авсан газраа дахин дамлаж газраа түрээслэж байжээ.

Сангийн газрыг түрээслэхийг “сүйлэн авах” гэнэ. Тарианы газрыг олгохдоо “суумал” гэх хэмжээг баримтлана. Энэ нь монголын хуучин үеийн нэгэн зүйл

¹² *Монгол төр, эрх зүйн түүх* (Дээж бичиг). Эрхлэн хэвлүүлсэн Б.Баярсайхан. Улаанбаатар: 2010, 96

¹³ Насанбалжир, Ц. *Мал аж ахуй хөтлөлтийн уламжлал, шинэчлэл*. Улаанбаатар: Шинжлэх ухааны академийн хэвлэлийн үйлдвэр, 1978, 27

багтаамжийн хэмжээ юм. Богдын санд төчнөөн жин цагаан гурил тушаана гэсэн хүнийг бас хөндлөнгөөс тусгай хүн батлан даана. Тариачин отгийн дарга нар уул гурилыг намар хураан авч санд тушаана. Энэ тухай дархивын баримтанд: “Чуулганы боолт 4 суумал газрыг дарга Цэрэндоржийн лам Лувсандорж 200 жин цагаан гурилаар сүйлэн\түрээслэн\ авсаныг дарга Равжаагийн лам Санж даав. Хураасан гурил 200 жин үүнийг тухай бүр өөрөө барив. Түрхүүрч Лувсан мөр бичүүлэв. Ар Чорндагийн боолтын газрыг Сэлэнгийн дарга Дэмбэрэл хязгаар хэмээх Баяр 1000 жин цагаан гурилаар сүйлэн авсаныг дарга Равжаа лам Лувсанцэрэн даав. Хураах цагаан гурил 1000 жин үүнээс 556 жинг гэлэн Дамба барив. Бас 444 жинийг өөрөө барив хэмээн Түлхүүрч Лувсан мөр бичүүлэв” гэжээ.¹⁴

Сүм хийдүүд тарианы газраа хүмүүст өгч түрээслэсэн талаар нарийн бичиг данс үйлдэж, тухайн ондоо тарианы газрын дарга нар хураан авч санд нийлүүлж байжээ. Тухайлбал:

Бага Цагаан овооны боолт 6 суумал газрыг 300 жин гурилаар сүйлнэ

Яст боолтын 2 суумал газрыг 100 жин цагаан гурилаар сүйлнэ.

Цагаан толгойн булагын суумал боолтийн 30 суумал газрыг 1500 жин цагаан гурилаар сүйлнэ.

Ар Бургалтай нь 15 суумал газрыг 800 жин цагаан гурилаар

Санж бандидын боолт 60 суумал газрыг 3000 жин цагаан гурилаар сүйлэн авсан.

Цэвээнжав Хайлаастын мухарын 3 боолт 50 суумал газрыг 2500 жин гурилаар сүйлэн авсан.

Хайрт боолтын 6 суумал газрыг 300 жин цагаан гурилаар

Ханж боолтын 8 суумал газрыг 400 жин

Дагат арын мухарын боолт 2 суумал газрыг 100 жин

Баруун наймтын 10 суумал газрыг 500 жин

Зүүн наймтын боомтын 1 суумал газрыг 50 жин

Хурдан Сономын боолтын 6 суумал газрыг 300 жин

Доод Арын боомт 2 суумал 100 жин гурилаар сүйлэсэн тухай тэмдэглэл бичиг хөтөлсөн байна.¹⁵ Тэрчлэн 1911 онд ван Цэрэнбаавайн хошууны лам Лувсанцэрэн Богдын сангаас тарианы газар түрээслэн авч, газрын хөлсөнд цагаан гурил 2750 жин, бас Их шавийн лам Соном, Дэмчиг нар цагаан гурил 1600 жин өгөхөөр тарианы газар түрээслэн авч байжээ.

¹⁴ УТА. А-74 Д-1, ХН-9

¹⁵ УТА. А-74 Д-1, ХН-9

Тариаг хэмжих нэгж нь Монголын баруун хэсэгт тогоо, умард хэсэгт дү хэмээх хэмжигдхүүн байжээ. Тогоо тариаг цайгаар арилждаг. 3 тогоо будаа 2 шахмал цай болно. Нэг тогоо будаа 1 шахмал цай болно. Хожгор арвай нэг тогоо нь нэг шахмал цай болно. / Нэг тогоо буудай, нэг тогоо арвайнаас ханшаар илүү байжээ. Учир нь улаан буудайн амт чанар сайн, цавуулаг ихтэй. Тогоо тариагаар арилжин авах зүйлийн үнэ ханш нутаг бүрт харилцан адилгүй байв. Ховдын Үенч суманд 1 морийг 25 тогоо, гүүг 10 тогоо, атан тэмээг 30 тогоо, ингийг 20 тогоо, нэг эр хонийг 2 тогоо, 2 ямааг 3 тогоо тариагаар, нэг гүзээ зөөхийг буюу 5 кг, 3 тогоо тариагаар арилжиж байв¹⁶. Нутгийн ардууд чулуун тээрэм өөрсдөө хийж бусдын тариаг хөлсөөр тээрэмдэж байсан тухай нэгэн сонирхолтой баримтыг дурдвал, харъяат хошууны хангай нутагт ядуулаг ардууд ... арга сүвэгчлэн буудай няцлах чулуун тээрэм хийж, аливаа гурил тээрэмдүүлэх хүний 100 жин бүрээс буудай нэг дү хөлс авч, алба аминд тус ашиг болгож байжээ.

Ийнхүү Монгол орны сүм хийдүүд байгаль, газар зүйн таатай нөхцөлд оршихын зэрэгцээ, нэгэнт олгогдсон газар нутаг тэлэхгүй, шавь нарын тоо улам бүр өсөн нэмэгдэх бодит байдал нь аж ахуй эрхлэлтийн зохион байгуулалт бүхий үйл ажиллагааны хэлбэрт шилжиж, тухайлбал газар тариалан эрхлэж тухайн цаг үеийн нийгмийн үйлдвэрлэл, хуваарилалтын процесст тодорхой үүрэг гүйцэтгэх болжээ.

Abstract: The Cultivation began to be devoted to the Khutugt's food and monastery pray ritual since second half of the XVIII century expanding monastery treasure. The Cultivation was the duty of the External treasure. The monastery had possibilities to have cultivation and get profit from it. These are:

1. The right to obtain land for the cultivation was maintained. The land of the 9 Khutugts of 13 of them possessed all sides of Khangai mountain range and Ider, Chuluut, Khanui, Khunui, Noerthans South Tamirs, Zavkhan, Baidrag, Olziit and Tuin rivers' basins alongside and perpendicularly.
2. The interest to be lama (teacher) and shabi (student) became common in Mongolian society and all new students were accepted despite their wealth amount. The students cultivated barley, six-rowed barley, wheat, buckwheat, millet and oat on the cultivating land. Mongolians cultivated three kinds of wheat as mild, hard, undersized and mild wheat were dominated. The hard wheat was cultivated only

¹⁶ Роломжав, Б. *БНМАУ-ын тариалангийн хураангуй түүх*. Улаанбаатар: ШУА-ийн хэвлэх үйлдвэр. 1987, 36.

in Khovd with mild wheat. The amount of grains that must be delivered to the monasteries was 5 du (100 kg) and it was duty. The unit to measure grain was cauldron in the west of Mongolia and du in the north. A cauldron grain cost a brick tea. Three cauldron grain cost 2 brick tea. A cauldron of barley cost a brick tea.

3. Increase of the students, former size of land and being in the monasteries as Khutugts lead to the socio-economy requirements to have more organized economy.

4. Releasing lama and their students from different taxes and duties in the Qing period and after the independence regaining in 1911 increased the number of students and gave possibility to cultivate wheat for the monastery legally.